Баянхонгор аймгийн ЗДТГ нь 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 13,543,490.2 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 6,063,846.9 мянган төгрөгөөр буюу 81 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	10,000.0	56,626.6	46,626.6
Бараа материал	265,997.1	308,456.1	42,459.0
Үндсэн хөрөнгө	9,012,276.0	15,253,127.4	6,240,851.4
Хуримтлагдсан элэгдэл	-1,808,629.8	-2,074,719.9	-266,090.1
Нийт хөрөнгө	7,479,643.3	13,543,490.2	6,063,846.9
Өр төлбөр	8,542.8		-8,542.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	7,471,100.5	13,543,490.2	6,072,389.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7,479,643.3	13,543,490.2	6,063,846.9

Эх сурвалж: Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан

Авлага дансны үлдэгдэл 56,626.6 мянган төгрөг болж 46,626.6 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн татаас санхүүжилтийн авлагаар тусгасан 42,444.9 мянга, шүүхийн шийдвэрээр 1 албан хаагчийн НДШ-ийг нөхөн мэдээлж авлагаар тусгасан 3,590.0 мянга мянган төгрөгийн авлага шинээр үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 308,456.1 мянган төгрөг болж 42,459.0 мянгаар өссөн нь төсвийн хөрөнгөөр 362,521.6 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч улсын Онцгой комиссоос 197,543.6 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлэн авсан ба үйл ажиллагаандаа 534,161.1 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 15,253,127.4 мянган төгрөг болж 6,240,851.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 111,369.4 мянга төгрөгийн хөрөнгө худалдан авсан, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Ингэний сүүний үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмж 3,848,147.3 мянга, Өвлийн хүлэмж 1,911,324.3 мянга, бусад эх үүсвэрээс 529,219.9 мянга нийт 6,432,721.4 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авч аймгийн ИТХ-ын тогтоолоор 199,370.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгасантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл тайлант онд үлдэгдэлгүй байгаа бөгөөд өмнөх оны 8,542.8 мянган төгрөгийн үлдэгдлийг барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 13,543,490.2 мянган төгрөг болж 6,072,389.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 6,072,389.7 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус

хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 3,963,628.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 1,543,340.2 мянган төгрөгөөр өсгөж 5,506,969.0 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 6,256,676.5 мянган төгрөг болгож 749,707.5 мянган төгрөгөөр өсгөн баталсан нь төрийн албан хаагчийн цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,278,135.7 мянган төгрөг батлагдсанаас 1,242,593.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 243,392.7 мянган төгрөг буюу 96 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 243,392.7 мянган төгрөгийг дутуу зарцуулсан нь голлох нөлөө үзүүлсэн байна

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	80101 үндсэн үйл ажиллагаа зардал	4,560,818.6	4,318,511.3	242,307.3	95%
2	80802 ажил олгогчоос олгох тэтгэмж	211,857.9	210,775.8	1,082.1	99%
3	81102 орон нутгийн нөөц хөрөнгө	1,448,000.0	1,447,996.6	3.4	100%
4	80205 мэдээлэл сурталчилгааны зардал	36,000.0	36,000.0	0.0	100%
	Нийт дүн	6,256,676.5	6,013,283.8	243,392.7	96%

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Үндсэн үйл ажиллагааны зардлаас 243,307.3 мянга буюу 5 хувь, , ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлаас 1,082.1 мянга буюу 1 хувь, орон нутгийн нөөц хөрөнгөөс 3.4 мянга нийт 243,392.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 8 төрлийн 857,681.7 мянган төгрөгийн санхүүжилт орж ирсэн.

Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого

/мян.төг/

№	ЭХ ҮҮСВЭРИЙН	
	Төрөл	Дүн
1	Тусгай зөвшөөрөл	858.0
2	UNITED NATIONS CHILDRENS FUND /НҮБ/	28,660.0
3	Хандив өвөлжилт	249,166.0
4	ПРАКТИКАЛ ДААТГАЛ ХХК	8,245.5
5	Түрээс-/урсгал засвар/	21,770.0
6	Бусад нийтлэг АҮТХураамж-/АЕГазар/	61,025.0
7	Хөдөө орон нутагт	213,750.8
8	Утаагүй уурын зуухны санхүүжилт	274,206.4
	Нийт дүн	857,681.7

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

Дээрх 857,681.7 мянган төгрөгийн орлогыг 814,797.1 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан ба оны эцэст 42,884.6 мянган төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлж 42,444.9 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар санхүүгийн тайланд тусгасан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, аудитын менежер М.Алтантуяа, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2025 оны 01 дүгээр сарын 23-д ирүүлсэн

2024 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор аймгийн ЗДТГ-ийн 1 дүгээр гарын үсгийг Д.Энхжаргал 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч С.Гэрэлмаа нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн

гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсвийн нийт зардлын 6,256,676.5 мянган төгрөгөөс тооцоход 62,566.8 мянган төгрөг байгаа ба гүйцэтгэлийн материаллаг байдлыг 65 хувиар буюу 40,668.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;" гэсэн заалтыг зөрчиж улс төрийн албан хаагч ажлаас чөлөөлөгдөхөд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 5 сарын цалинтай тэнцэх хэмжээний 1,0395.0 мянган төгрөгийн нэг удаагийн мөнгөн шагнал урамшуулал олгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2024 онд 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 166 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд Шилэн дансны цахим сайтад 5 сая төгрөгөөс цалингийн зардлаас бусад орлогын гүйлгээний 3,537,209.8 мянган төгрөгийн 42 мэдээлэл мэдээлэхээс бүрэн мэдээлсэн, 5 сая төгрөгөөс цалингийн зардлаас бусад зардлын гүйлгээний 2,892,220.4 мянган төгрөгийн 146 гүйлгээ мэдээлэхээс 2,519,641.1 мянган төгрөгийн 107 гүйлгээ мэдээлж 372,579.3 мянган төгрөгийн 39 гүйлгээ мэдээлээгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 107,920.0 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрснээс 107,920.0 мянган төгрөгийн зөрчил арилгах 4 албан шаардлага өгсөн ба аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн даргын 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 3/900 дугаар албан бичгээр хэрэгжилтийг тооцсон байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	107,920.0	4	107,920.0	100
Нийт дүн	4	107,920.0	4	107,920.0	100

Эх сурвалж: 2024 оны аудитын тайлангаас

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Ингэний сүүний үйлдвэрийн 3,848,147.3 мянган төгрөгийн үнэ бүхий барилга тоног төхөөрөмжийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 517 дугаар тогтоолоор Аймгийн ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэсэн байна.

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн өвлийн хүлэмж, усалгааны системийн 1,911,324.3 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 517 дугаар тогтоолоор Аймгийн ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэсэн байна.

3. Аймгийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 246,800.0 мянган төгрөгийн өртөгтэй 2 автомашиныг худалдан авч аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 99 дүгээр захирамжаар тус байгууллагын үндсэн хөрөнгөд орлого авсан байна.

Дээрх асуудлуудыг аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар авч үзэхээр шийдвэрлэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 513.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

1. Тайлант оны 11 сард цалингийн урьдчилгаанд 68,341.3 мянган төгрөгийн олгосон ба нягтлан бодогч 67,981.5 мянган төгрөгийг суутгаж 359.7 мянган төгрөгийн авлагаар бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх" 13 дугаар зүйлийн 13.4 дахь "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Нэг албан хаагчийн 7 сарын амралтын цалин бодохдоо буруу тооцоолсноос шалтгаалж зөрүүг харилцах дансанд тушаасан ба ХАОАТ-ыг илүү тооцсон цалингаар тооцож 154.1 мянган төгрөгийг татварын алба руу илүү шилжүүлж авлага үүсгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх" 13 дугаар зүйлийн 13.4 дахь "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 534,921.0 мянган төгрөгийн 8 зөрчил² илэрснээс 4,678.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 372,579.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага, 20,250.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

1. Аймгийн Засаг даргын туслах өндөр настны тэтгэмж тогтоолгох эрх үүсэж Аймгийн ЗДТГ-ын даргын 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн Б/34 дүгээр тушаалаар 33,686.0 мянган төгрөг буюу 36 сарын тэтгэмж олгосон байна. Өндөр настны тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийн хэмжээг давтан тооцоолж үзэхэд тус албан хаагч шимтгэл төлсөн нийт хугацаа 30 жил 6 сар байгаа бөгөөд 29,007.4 мянган төгрөгийн тэтгэмж авахаар байгаа бөгөөд 4,678.6 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь "Энэ журмын 1.1-д заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөж, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон төрийн албан хаагчид 2.1-д зааснаар тогтоосон үндсэн цалингийн дунджийг нь төрийн албанд

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ажилласан нийт жилийн тоотой тэнцэх сарын тоогоор үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон тэтгэврийн зөрүү 4,678.6 мянган төгрөгийг холбогдох албан хаагчаар төлүүлж орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Аймгийн Засаг даргын 2024 оны 12 сарын 25-ны өдрийн А/736 дугаар "Нөөц хөрөнгө зарцуулах тухай" захирамжаар Баянхонгор аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 131/ШШ2024/00673 дугаартай захирамжийн дагуу Т.Норовын 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл ажилгүй байсан хугацааны НДШ, ЭМД-ын шимтгэл болох 3,590.0 мянган төгрөг төлөх шийдвэр гаргаж 2024 оны 12 сарын 26-ны өдөр шилжүүлсэн байна.

Энэ нь Захиргааны Ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1. "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Гэм буруутай этгээдээр эргэн төлүүлж авлагыг барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

2. Аймгийн Засаг даргын 2024 оны 12 сарын 06-ны өдрийн Б/111 дүгээр тушаалаар Засаг даргын орлогчийг албан ажлаас чөлөөлөгдөхөд нь таван сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 10,395.0 мянган төгрөгийн нэг удаагийн мөнгөн шагнал урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3 дахь "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Улс төрийн албан тушаалтанд олгох мөнгөн тэтгэмжийн хуульд заасны дагуу тухайн байгууллагын төсөвт суулган шийдвэрлэж байх, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3. Байгууллагын даргын тушаал шийдвэр гараагүй байхад Ээлжийн амралтаа биеэр эдлээгүйн нөхөн олговрыг 1.5 нэмэгдүүлэн Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн мэргэжилтэнд 3,072.6 мянга, няравт 3,387.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно." гэсэн заалтыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын даргын тушаал гарган зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4. Тус байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь оны эхэнд өмч хамгаалах зөвлөлийн ажлын төлөвлөгөө гаргасан боловч улирал бүр тайлан гаргадаггүй, хөрөнгө худалдан авах, зарцуулахдаа өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гаргадаггүйгээс тайлант онд авто машины сэлбэг хэрэгслийн зардалд 68,968.5 мянган төгрөгийн зарцуулсан боловч өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гаргаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13-т "Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт нь баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана" 31 дүгээр зүйлийн 31.3 дахь "Худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь тээврийн хэрэгслийн сэлбэг, эд ангийг солихдоо батлагдсан норм стандартын дагуу тухай бүр дүгнэлт гаргаж зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

5. Засаг даргын нөөц хөрөнгөөс аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 29-ны өдрийн А/120 дугаар захирамжаар БНА0001 автомашины сэлбэг засварт зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн нөөц хөрөнгийн зориулалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тухайн байгууллагын үйл ажиллагаанаас зардлаас санхүүжүүлж байх, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

6. Тайлант онд Шилэн дансны цахим сайтад 5 сая төгрөгөөс цалингийн зардлаас бусад зардлын гүйлгээний 2,892,220.4 мянган төгрөгийн 146 гүйлгээ мэдээлэхээс 2,519,641.1 мянган төгрөгийн 107 гүйлгээ мэдээлж 372,579.3 мянган төгрөгийн 39 гүйлгээ мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 дахь "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, орхигдуулсан мэдээллийг байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нөхөн мэдээлэх албан шаардлагыг хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

1. Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/35 дугаар захирамжаар Төрийн албан хаагчдыг туршлага судлах, аяллын зардалд Засаг даргын нөөц хөрөнгөөс 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр "Мазаалай номадик тур" ХХК руу 20,250.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх "Хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийг журмын дагуу зарцуулж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэв

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oO-----

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Аймгийн Засаг даргын туслах өндөр настны тэтгэмж тогтоолгох эрх үүсэж Аймгийн ЗДТГ-ын даргын 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн Б/34 дүгээр тушаалаар өндөр настны тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийн зардалд 33,686.0 мянган төгрөгийг олгосон бөгөөд дээрх албан тушаалтан шимтгэл төлсөн нийт хугацаа 30 жил 6 сар байгаа бөгөөд 29,007.4 мянган төгрөгийн тэтгэмж авахаар байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь заалтыг зөрчсөн байна.	1	4,678.6	1	4,678.6				
Аймгийн Засаг даргын 2024 оны 12 сарын 25-ны өдрийн А/736 дугаар "Нөөц хөрөнгө зарцуулах тухай" захирамжаар Баянхонгор аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 131/ШШ2024/00673 дугаартай захирамжийн дагуу Т.Норовын 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл ажилгүй байсан хугацааны НДШ, ЭМД-ын шимтгэл болох 3,590.0 мянган төгрөг төлөх шийдвэр гаргаж 2024 оны 12 сарын 26-ны өдөр шилжүүлсэн байна. Энэ нь Захиргааны Ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1. дэх заалтыг зөрчсөн байна.	1	3,590.0			1	3,590.0		
Ээлжийн амралтаа биеэр эдлээгүй гэсэн шалтгаанаар 12 сарын цалинтайгаа хамт ээлжийн амралтын олговрыг 1.5 нэмэгдүүлэн Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн мэргэжилтэн 3,072.6 мянга, нярав 3,387.0 мянган төгрөгийг ямар нэгэн тушаал шийдвэргүйгээр олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх заалтуудыг зөрчсөн байна.	1	6,459.6			1	6,459.6		
Тайлант онд авто машины сэлбэг хэрэгслийн зардалд 68,968.5 мянган төгрөгийн зарцуулсан боловч өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гаргаагүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13-т дэх заалт, 31 дүгээр зүйлийн 31.3 дахь заалтуудыг зөрчсөн байна.	1	68,968.5			1	68,968.5		
Засаг даргын нөөц хөрөнгөөс аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 29-ны өдрийн А/120 дугаар захирамжаар БНА0001 автомашины сэлбэг засварт 48,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн нөөц хөрөнгийн зориулалттай нийцэхгүй байна.	1	48,000.0			1	48,000.0		
Нийт дүн	5	131,696.7	1	4,678.6	4	127,018.1		

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн хуультай холбоотой								
Аймгийн Засаг даргын 2024 оны 12 сарын 06-ны өдрийн Б/111 дүгээр тушаалаар засаг даргын орлогч ажлаас чөлөөлөгдөхөд нь таван сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 10,395.0 мянган төгрөгийн нэг удаагийн мөнгөн шагнал урамшуулал олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3 дахь заалтыг зөрчсөн байна.	1	10,395.0			1	10,395.0		
Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/35 дугаар захирамжаар Төрийн албан хаагчдыг туршлага судлах, аяллын зардалд Засаг даргын нөөц хөрөнгөөс 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр "Мазаалай номадик тур" ХХК руу 20,250.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтуудыг зөрчсөн байна.	1	20,250.0					1	20,250.0
Дүн	2	30,645.0			1	10,395.0	1	20,250.0
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант онд Шилэн дансны цахим сайтад 5 сая төгрөгөөс цалингийн зардлаас бусад зардлын гүйлгээний 2,892,220.4 мянган төгрөгийн 146 гүйлгээ мэдээлэхээс 2,519,641.1 мянган төгрөгийн 107 гүйлгээ мэдээлж 372,579.3 мянган төгрөгийн 39 гүйлгээ мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ." 6.4.5 дахь заалтыг зөрчсөн байна	1	372,579.3			1	372,579.3		
Дүн	1	372,579.3			1	372,579.3	1	20,250.0
Нийт дүн	3	403,224.3			2	382,974.3	1	20,250.0

-----oOo-----